



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 5/44

Дуурсах

Ажил хавсран гүйцэтгүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 9 дүгээр тогтоолын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Удирдлагын зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хурлын шийдвэр, мэргэжилтэн Э.Даваасүрэнгийн өргөдлийн дагуу Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн О.Найгалмааг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл, үнэлгээ хариуцсан мэргэжилтний ажил үүргийг түр орлон гүйцэтгүүлсүгэй.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2022 оны 03 сарын 14-ний өдрийн Б/31 дүгээр тушаалыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай

3. Түр орлон гүйцэтгэх хугацаанд тухайн албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар урамшуулал олгохыг ерөнхий нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (С.Батцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ЭНХЖАРГАЛ

